



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 8/91

Ховд

Ц.Мөнх-Эрдэнийг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Дотоод ажил, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэнд-Аюушийн Мөнх-Эрдэнэ нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан тул 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн тасалбар болгон ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Ц.Мөнх-Эрдэнэтэй холбогдох тооцоог хийж дуусгахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2022 онд 10 дугаар сарын 28-ны
өдрийн Б/9 дүгээр тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

П.Мандухай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Х.Болормаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав)

Нарийн бичиг: Н.Цэрмаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

-oOo-